

**БАТЛАВ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА**

Ш.НОХОЙЖАВ

**НЭГДСЭН ДУЛААНД ХОЛБОГДСОН СУМДЫН АЛБАН
БАЙГУУЛЛАГУУДЫН ДУЛААНЫ ТООЛУУР
ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ
БИЧИГ**

Төслийн нэр: Нэгдсэн дулаанд холбогдсон сумдын албан
байгууллагуудын дулааны тоолуур худалдан авах ажил

Төслийн дугаар: ХОАОНӨГ/202001079

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.09.25

Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Нэгдсэн дулаанд холбогдсон сумдын албан байгууллагуудын дулааны тоолуур худалдан авах ажил** үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn цахим хуудсанаас татаж авч болох бөгөөд тендерт оролцох хүсэлтээ www.tender.gov.mn. цахим эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянга/** төгрөгийг тушааж оролцох эрхээ бүртгүүлнэ.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 10 дугаар сарын 02 -ны өдрийн 10:00 цаг-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 10:30 минутад Орон нутгийн өмчийн газрын 415 тоот өрөөнд нээлтийг** хийнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар 4
давхар 407 тоот Орон нутгийн өмчийн газрын
мэргэжилтэн Э.ЦОЛМОН, Утас: 70434401,
88011269 www.tender.gov.mn**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**7. Санал
болгосон үнэ,
түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p>Нэгдсэн дулаанд холбогдсон сумдын албан байгууллагуудын дулааны тоолуур худалдан авах ажил</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>Батлагдсан төсөвт өртөг: 40 000 000</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлэх 2. Нийгмийн даатгалын тодорхойлолт /өр төлбөргүй эсэх, эх хувь /эх хувь, тендер зарласан хугацаанд авсан тодорхойлолт байна/ 3. Харилцагч банкны тодорхойлолт /эх хувь, тендер зарласан хугацаанд авсан тодорхойлолт байна/ 4. Татварын хэлтсийн тодорхойлолт шаардлагагүй нээсэн өдрийн байдлаар системээр дамжуулан лавлагааг авч үзнэ. /өр төлбөргүй байх шаардлагатай./ 5. Шүүх байгууллагын тодорхойлолт /эх хувь, Анхан шатны шүүхээс/ /эх хувь, тендер зарласан хугацаанд авсан тодорхойлолт байна/ 6. Сүүлийн 1 жилийн хугацаанд нийлүүлсэн туршлагатай байх бөгөөд нийлүүлсэн барааны гэрээ, актыг ирүүлэх, 7. Нийлүүлсэн барааны чанарын талаар өмнөх захиалагчийн тодорхойлолт 8. Нийлүүлэх барааны загвар тодорхойлолт, гэрэл зураг, тэдгээрийн үнэн болохыг гэрчилсэн баримт бичиг ирүүлэх /алдаагүй, зөрүүгүй илэрхийлсэн байх/ 9. Бараа нийлүүлэлтийн хуваарийг тендерийн баримт бичигт заагдсан маягтын дагуу гаргаж ирүүлэх 10. Захиалагч талаас дээрх мэдээллүүдийг мөн цахим системээр давхар шалгана. Ирүүлсэн мэдээлэл системийн мэдээлэлтэй зөрөх эсхүл нийлүүлсэн бараа нь шаардлага хангахгүй бол гэрээний үүргээ зөрчсөн, худал мэдээлэл ирүүлсэн гэж үзэн холбогдох газарт материалыг хүргүүлж хар жагсаалтад бүртгэгдэх болохыг анхаарна уу. 11. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод гаргацтай байх шаардлагатай. 12. Илгээсэн материалыг бүрэн гүйцэд алдаагүй илгээх хариуцлагыг тендерт оролцогч өөрөө хариуцна. 13. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн барааг нийлүүлж хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. 14. Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мөн харилцагч банк, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсээс лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл ирүүлнэ. 15. Тендерийн баримт бичигтэй нэг бүрчлэн танилцаж жишиг маягтын дагуу бөглөж ирүүлэхийг анхаарна уу! 16. Төсөвт өртөг: 40 000 000 төгрөг 17. Дээрх материалуудыг ирүүлээгүй буюу дутуу, шаардлага


хангаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.
18.Санхүүгийн 2019 оны тайлан аудитын дүгнэлтийн хамт

ТӨЭЗ 2.1

	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Ховд аймаг Жаргалант сум. Нутгийн удирдлагын ордон. Орон нутгийн өмчийн газар Давхар болон өрөөний дугаар: 4 давхар 407 тоот өрөө Огноо: 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут
ТӨЭЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:
ТӨЭЗ 2.3	Байгууллагын хаяг: Ховд аймаг Жаргалант сум. Нутгийн удирдлагын ордон. Орон нутгийн өмчийн газар Давхар болон өрөөний дугаар: 4 давхар 407 тоот өрөө Огноо: 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Цаг: 10 цаг 30 минут
ТӨЭЗ 6.2	Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: <ol style="list-style-type: none">1. Үнийн санал2. Бараа нийлүүлэх хуваарь
	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй.

Батлав

Засаг даргын орлогч



Т.Жаргалсайхан

НЭГДСЭН ДУЛААНД ХОЛБОГДСОН СУМДЫН АЛБАН БАЙГУУЛЛАГУУДЫН
ДУЛААНЫ ТООЛУУР АВАХ

2020.09.17

Ховд хот

№	Төсөл боловсруулах үндэслэл	-Ховд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.6.2-д тусгагдсан - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 10 дугаар хуралдааны 10/06 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтанд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.41-д тусгагдсан.
1	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	Нэгдсэн дулаанд холбогдсон сумдын албан байгууллагуудын дулааны тоолуур авах
2	Зориулалт, хүчин чадал	Нийт 12 сумдын албан байгууллагуудын дулааны тоолуур тавих
3	Одоогийн байдал	Нийт 12 сумдын албан байгууллагуудын дулааны тоолуур тавих
4	Төсөл гүйцэтгэх хугацаа	2020 он дотор
5	Төслийн захиалагч	Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар
6	Төсөл боловсруулах үе шат	- Ажлын төсөв гаргах
7	Зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд:	Нэгдсэн дулаанд холбогдсон сумдын албан байгууллагуудын дулааны тоолуур авах 1. D25 диаметртэй тоолуур 3 ш 6 тн/цаг хүчин чадалтай герман улсад үйлдвэрлэсэн D25 диаметртэй тоолуур 2. D20 диаметртэй тоолуур 9 ш 2,5 тн/цаг хүчин чадалтай герман улсад үйлдвэрлэсэн D20 диаметртэй тоолуур 3. Хөг шүүгч D20 - 9ш 4. Хаалт D20 – 18ш 5. Хөг шүүгч D25 - 3ш 6. Хаалт D25 – 6ш 7. Турба D20 – 12м 8. Турба D25 – 6 м 9. Боолт – M12- 80ш 10. Пиланз D20 – 18ш 11. Пиланз D25 – 6ш 12. Нийт 12 суманд тоолуур суурилуулах үүнд: Алтай, Үенч, Ховд, Цэцэг, Манхан, Зэрэг, Мянгад, Дөргөн, Эрдэнэбүрэн, Чандмань, Дарив, Дуут, сумуудад тоолуур суурилуулах .
8	Зураг төсвийн үнэ	Уг төсөл арга хэмжээнд зургийн үнэ байхгүй

БОЛОВСРУУЛСАН:
ХОХБТХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН



Д ЭРДЭНЭБАТ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ ОРУУЛАХ

2. **Баглаа, боодол:** [Нийлүүлэх барааны үйлдвэрийн баглаа, боодлыг хөндөөгүй байх бөгөөд хэрэв хөндсөн байвал барааг хүлээн авахаас татгалзаж гэрээг цуцлана.]

3. **Бараа хүргэх газар:** [Ховд аймгийн Жаргалант сум 7-р сургууль]

4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ							
Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
	Нэгдсэн дулаанд холбогдсон сумдын албан байгууллагуудын дулааны тоолуур худалдан авах ажил	Ширхэг		Ховд аймаг Алтай сум, Үенч, Ховд, Цэцэг, Манхан, Зэрэг, Мянгад, Дөргөн, Эрдэнэбүрэн, Чандмань, Дарив, Дуут сумуудад тоолуур суурилуулах	2020 оны 10-р сарын 15	2020 оны 10-р сарын 30	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших**

1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**

2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
- 3. Оюуны өмчийн эрх**

3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
- 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх**

4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 5. Баталгаат засварын хугацаа**

5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[тоо]** жил байна.
- 6. Гэрээнд өөрчлөлт оруулах**

6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөлтөөрчлөхгүй.
- 7. Төлбөр**

7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
- 8. Бараа нийлүүлэх хуваарь**

8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 9. Алданги оногдуулах**

9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
- 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах**

10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**

11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. **Шалгах**^{1.1.} [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх болон турших (ГЕН – 1) шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. **Барааны**^{2.1.} Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. **Баталгаат**^{5.1.} Баталгаат засварын тусгай шаардлага.
засвар (ГЕН-5) [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. **Төлбөр**^{7.1.} Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
(ГЕН – 7)
- Гэрээний үнийн дүнгийн **[тоо]**¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. **Алданги**^{9.1.} Алданги оногдуулах хувь: **[0.05]**
оногдуулах (ГЕН - 9)² Алдангийн нийт дүн: **[5 хувь]**

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴ ;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь; Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]